



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 546

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан ажлын хэрэгцээнд зориулан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр нийт 246,900,000.00 (хоёр зуун дөчин зургаан сая есөн зуун мянган) төгрөгт багтаан 6 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга Х.Оюунболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001514

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны ... дугаар сарын ... ны өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ХУДАЛДАН АВАХ
 АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 1500 cc хүртэл	1	26,950,000.00	26,950,000.00
2	Суудлын тоо 12, хөдөлгүүрийн багтаамж 3000 cc хүртэл	5	43,990,000.00	219,950,000.00
	Нийт дүн			246,900,000.00 (хоёр зуун дөчин зургаан сая есөн зуун мянган)